

ДОРНОД АЙМГИЙН 2017 ОНЫ ҮОЙ ӨЕ 5 САРЫН ЭРҮҮ, ХЭВ ЖУРМЫН
НӨХЦӨЛ БАЙДЛЫН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2017.06.04

Хэрлэн сум

Дорнод аймгийн хэмжээнд 2017 оны үой өе 5 сард 2.139.300.000 төгрөгний хохиролтой 202 холбогдогчтой, эрүүгийн 204 хэрэг бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 4 хэргээр буюу 1.9 хувиар буурчээ.

Гэмт хэргийн илрүүлэлт 72.6 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.2 пунктээр өссөн байна.

Гэмт хэргийн улмаас 6 хүн нас барж, 104 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад нас барсан хүн ижил түвшинд, гэмтсэн хүний тоо 7 нэгж буюу 7.2 хувиар өссөн байна.

Иргэд аж ахуйн нэгж байгууллагад учирсан хохирлын 206.800.000 төгрөг буюу 9.7 хувийг нөхөн төлүүлсэн.

Дээрэмдэх хэрэг 3 хэргээр буюу 3 дахин, булаах хэрэг 1 хэргээр буюу 100 хувь, зам тээврийн гэмт хэрэг 3 нэгжээр буюу 37.5 хувь, хүнийг санаатай алах хэрэг 1 хэргээр буюу 200 хувь, бусдын биемахбодид гэмтэл учруулах хэрэг 3 хэргээр буюу 3,7 хувиар, танхайрах хэрэг 2 хэргээр буюу 50.0 хувиар, шүүн таслах ажиллагааны эсрэг хэрэг 1 хэргээр 100 хувиар **өсч**, хүчиндэх хэрэг 2 хэргээр буюу 40,0 хувиар, хулгайлах хэрэг 4 хэргээр буюу 6.0 хувиар, залилах хэрэг 2 хэргээр буюу 33.3 хувиар, бусдыг амиа хорлоход хүргэх хэрэг 2 хэргээр буюу 66.7 хувь, байгаль хамгаалах журмын эсрэг хэрэг 2 хэргээр буюу 66.7 хувиар, завших хэрэг 1 хэргээр буюу 33.3 хувиар, захиргааны журмын эсрэг хэрэг 1 хэргээр буюу 33.3 хувиар, бусад төрлийн хэрэг 5 хэргээр буюу 25.0 хувиар **буурч**, эд зүйл хууль бусаар хил нэвтрүүлэх, эм бэлдмэл, бодис хууль бусаар тээвэрлэх хэргүүд урьд оны **ижил** түвшинд байна.

*Мал хулгайлах хэрэг 4 хэргээр буюу 19.0 хувиар **буурч**, иргэдийн өмчийн хулгай 1 хэргээр буюу 2.3 хувиар **өссөн** үзүүлэлттэй байна.*

Хүндэвтэр гэмт хэргийн гаралт 12 хэргээр буюу 17.1 хувиар, онц хүнд гэмт хэргийн гаралт 1 хэргээр буюу 50.0 хувиар өсч, хөнгөн хэргийн гаралт 11 хэргээр буюу 9.1 хувиар, хүнд хэргийн гаралт 6 хэргээр буюу 40.0 хувиар буурчээ.

Хүндэвтэр хэргийн илрүүлэлт 74.0% байгаа нь 2.3 пунктээр өсч, хөнгөн хэргийн илрүүлэлт 65.5% байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.2 пункт, хүнд хэргийн илрүүлэлт 77.8% байгаа нь 9.7 пунктээр тус тус буурсан байна.

Тухайн онд шинээр иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гэмт хэрэг, захиргааны зөрчлийн шинжтэй гомдол мэдээлэл 2978 хүлээн авсан нь урьд оны мөн үеэс 225 буюу 7.0 хувиар буурчээ.

Гэмт хэргийн талаарх 666 гомдол мэдээлэл шийдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 179 буюу 21.2 хувиар, зөрчлийн талаарх 2224 гомдол мэдээлэл шийдвэрлэсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 33 буюу 1.5 хувиар буурсан ба 158 нь шийдвэрлэгдээгүй үлдэгдлээр байна.

Цагдаагийн байгууллагад ирүүлсэн болон цагдаагийн алба хаагч нараас илрүүлсэн захиргааны зөрчил 7046 байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 126 буюу 1.8 хувь өсч, үүнээс 193 жолоочийн тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч торгосон нь өнгөрсөн оны мөн үеэс 126 буюу 39,5 хувиар буурсан ба 261 хүнд баривчлах шийтгэл ногдуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 50 буюу 23.7 хувиар өссөн, зөрчил гаргасан 6592 иргэн, албан тушаалтан, байгууллага байгаа нь өнгөрсөн оны мөн үеэс 202 буюу 3.2 хувиар өсч, 210.155.400 төгрөгний торгууль ногдуулсан нь өнгөрсөн оны мөн үеэс 5.871.000 төгрөг буюу 2.7 хувиар буурсан, архи дан согтуурч захиргааны зөрчил гаргасан 1865 хүнийг эрүүлжүүлсэн нь 87 буюу 4.4 хувиар буурсан байна үзүүлэлттэй байна.